

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Анги 11.020

Эрүүлийг хамгаалах технологи Рашаан сувиллын бүтэц, үйл ажиллагаа Ерөнхий шаардлага	MNS 5232 : 2003
Health care technology Structure and function of the balneotherapy General requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2003 оны 3-р сарын 27-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2003 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчинтэй

Энэ стандартын норматив, шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь рашаан сувиллын бүтэц, үйл ажиллагааны түвшинг үнэлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэ стандарт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр рашаан сувиллын үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, өмчийн бүх хэлбэрийн рашаан сувиллуудыг магадлан итгэмжлэхэд хамаарах бөгөөд, тэдний бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ хийж дүгнэлт өгөхөд хэрэглэнэ.

3 Норматив ишлэл

Энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлүүд. MNS4621:98
- Барилга, байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ. MNS 1140:1987
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2000
- Галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага. MNS 4244:1994
- Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ. MNS 12.013:1991
- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт. MNS 900:1992
- Ажлын байрны агаарт байж болох цацраг идэвхит бодисын хэмжээ. MNS12.05.051:91
- Ажлын байрны хүчдэлийн түвшин. MNS 12.097:91, 12098:91, 12.101:91
- Хөрс, хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ. MNS 3297:91
- Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газрын доорх усыг бохирдлоос

MNS 5232 : 2003

- хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3342:82
- Байгаль хамгаалал. Газар. Газар эдэлбэр. Газар ашиглалт нэр томъёо. Тодорхойлолт. MNS 3473:83
- Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. MNS 0017-2-3-16:88
- Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага. MNS 0012:91
- Усны чанар. Хаягдал ус. MNS 4943:2000
- Амралт, сувиллын газрын үйлчилгээ. MNS 4958:2000
- Хоолны газрын үйлчилгээ. MNS 4946:2000

4 Нэр томъёо ба тодорхойлолт

Рашаан сувилал: Эмчлэн сэргийлэх зорилгоор ашиглаж байгаа байгалийн эмчилгээний нөөцтэй, барилга байгууламж, тоног төхөөрөмж бүхий тусгай хамгаалалттай, дэвсгэр нутагтай, эрх бүхий эрүүл мэндийн байгууллага(хуулийн этгээд)

Рашаан сувиллын тусламж, үйлчилгээ: Найрлага, үйлчилгээ нь шинжилгээгээр тогтоогдсон байгалийн рашаан, шавар, ус, агаар болон эмийн бус эмчилгээний төрлүүдийг ашиглан эмчилгээ, сувилгаа үзүүлэх үйл ажиллагаа

5 Удирдлага, бүтэц, зохион байгуулалт

5.1 Удирдлагын баг

5.1.1 Төрийн өмчийн байгууллагыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭМАЭТЗТБ) буюу орон нутгийн засаг захиргаанаас, өмчийн бусад хэлбэрийн байгууллагыг тухайн аж ахуйн нэгжийн удирдах зөвлөлөөс томилогдсон захирал /дарга/ удирдлагын багийг удирдана.

5.1.2 Тухайн рашаан сувиллын захирал (ерөнхий менежер) удирдлагын багийг бүрдүүлж ажиллана.

5.1.3 Рашаан сувиллын захирал /дарга/ нь ЭМАЭТЗТБ, буюу аж ахуйн, нэгжийн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулж ажиллана.

5.2 Удирдлагын багийн гишүүдийн манлайлал

5.2.1 Удирдлагын багийн гишүүд нь менежментийн мэдлэг, ур чадвар эзэмшсэн, эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой, ажлын дадлага туршлагатай байна.

5.2.2 Багийн гишүүд нь тус бүрийн мэргэжлийн ба төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээнд төлөвшсөн байна.

5.3 Удирдлагын багийн гүйцэтгэх үүрэг

5.3.1 Рашаан сувиллын зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог дээшлүүлэх.

5.3.2 Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг улирал тутамд гаргаж хагас, бүтэн жилээр тайлагнах

5.3.3 Удирдлагын багаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гаргаж байгаа шийдвэрүүдийг баримтжуулан, биелэлтийг хамт олондоо тогтмол мэдээлэх

5.3.4 Эрүүл ахуйн хэм хэмжээ, халдвараас сэргийлэх дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж ажиллах.

5.3.5 Рашаан сувиллын төсвийг үр ашигтай захиран зарцуулж, дотоод нөөц бололцоог бүрэн тооцож, оновчтой хуваарилах.

5.3.6 Эмчилгээ, сувилгааны эдийн засгийн үр ашгийг тооцон, өртөг зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

5.3.7 Гадаад, дотоодын рашаан сувиллын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн рашаан сувиллын мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулан үйл ажиллагаанд ашиглах.

5.3.8 Рашаан сувиллын статистик мэдээллийн үнэн зөв, шуурхай байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийн, тулгамдаж байгаа асуудлуудыг судалж, шийдвэр гаргахдаа хэрэглэх.

5.3.9 Рашаан сувиллын техник, технологийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

5.3.10 Эмчилгээ, үйлчилгээний чанарын менежерийн ажилд хяналт тавих.

5.3.11 Сувилуулагч, ажилтнуудын санал, гомдол, сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэлт хийж ажиллах.

5.3.12 Рашаан сувиллын бүсийн болон, рашааны орд газрын ариун цэвэр, байгаль орчны нөхөн сэргээлт, экологийн тэнцвэрт байдалд хяналт тавьж ажиллах

5.4 Ажлын төлөвлөгөө хөтөлбөр

Рашаан сувилал нь үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

5.5 Рашаан сувиллын бүтэц

5.5.1 Холбогдох Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай нэгж хэсгүүдтэй байна.

5.5.2 Сувилуулагчдад зориулж дараах үндсэн үйлчилгээг үзүүлнэ.

5.5.2.1 Оношлогоо

5.5.2.2 Эмчилгээ

5.5.2.3 Сувилгаа

5.5.2.4 Нөхөн сэргээх

5.5.2.5 Хоол хүнсээр хангах

5.5.2.6 Нийтлэг үйлчилгээ

- харуул хамгаалалт
- угаалга
- телевиз, радио
- холбоо
- засвар үйлчилгээ

5.5.2.7 Бусад үйлчилгээ

- Эмийн сан
- Ариун цэврийн болон соёлын барааны худалдаа
- Сувилуулагчдын чөлөөт цагийг идэвхитэй өнгөрүүлэхэд зориулсан үзвэр (кино, концерт, үдэшлэг, бүжиг) гэх мэт
- Спорт тоглоомууд
- Номын сан, өдөр тутмын хэвлэлээр үйлчлэх.
- Халуун ус
- Саун
- Үсчин
- Гоо сайхан

5.5.2.8 Рашаан сувилал өөрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах дараах нэгжтэй байна

- Аж ахуй, санхүү
- Гал тогоо
- Инженер, бальнеотехникийн засвар үйлчилгээ.
- Автограж
- Туслах аж ахуй
- Цэвэрлэгээ үйлчилгээ
- Угаалга
- Ариутгал
- Хог хаягдлын устгал, зайлуулалт

5.6 Рашаан сувиллын ор

5.6.1 Рашаан сувиллын орны тоог Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн аж ахуйн нэгжийн удирдах зөвлөл, нийгмийн даатгалын байгууллагатай зөвшилцөж тогтооно.

5.6.2 Рашаан сувиллын ор нь тухайн орон нутгийн эмнэлгийн орны тоонд орохгүй.

5.6.3 Клиник тасагтай байнгын ажиллагаатай рашаан сувилалд нийт орны 15% нь клиникийн тасгийн, 1% нь тусгаарлах ор байна.

5.6.4 Улирлын чанартай рашаан сувилал нь клиникийн оргүй байна.

6 Рашаан сувиллын санхүү

6.1 Рашаан сувиллын санхүүгийн тогтвортой байдлыг хангаж үр ашигтай ажиллах

6.2 Төрийн өмчит рашаан сувиллын санхүүжилтийн төсвийг эх үүсвэр бүрээр тооцон нэгтгэж төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн заалтын дагуу системийн ерөнхий менежертэй гэрээ байгуулна.

6.2 Хүний нөөцийн төлөвлөлт

Байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тухайн мэргэжлээр дадлагажуулах, хөгжүүлэх, тасралтгүй сургах, хүний нөөцийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

7.2 Ажлын байрны тодорхойлолт

Ажлын байрны тодорхойлолтыг Монгол Улсын Төрийн Захиргааны Албаны Зөвлөлөөс баталсан журмын дагуу боловсруулж мөрдүүлнэ.

7.3 Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл

Рашаан сувиллын эмч, мэргэжилтэн бүр эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байна.

7.4 Номын сан

7.4.1 Рашаан сувилал нь эмч мэргэжилтнүүд үйл ажиллагаандаа болон мэдлэг, мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэхэд ашиглах мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, яаралтай тусламжийн лавлах, мэргэжлийн болон тогтмол хэвлэл, хууль эрхийн мэдээлэл бүхий номын сантай байна. Сувилуулагчдад зориулж уран зохиолын болон бусад ном, тогтмол хэвлэлээр үйлчилнэ.

7.4.2 Номын сангийн дэргэд сургалт арга зүйн кабинет ажиллаж мэргэжлийн мэдээллээр хангана.

7.5 Рашаан сувиллын мэргэжилтний орон тоо

7.5.1 Тухайн рашаан сувиллын үйлчлэх хүрээ, хүчин чадлаас хамаарч эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтны орон тоог тогтооно. / А1, А2, А3 хавсралт /

7.5.2 Рашаан сувиллын эмч нь эмчийн ерөнхий мэргэжлээс гадна рашаан ус, шавар эмчилгээ, эмийн бус эмчилгээ (зүү төөнүүр засал, эмчилгээний биеийн тамир, физик эмчилгээ гэх мэт)-ний нарийн мэргэжил эзэмшсэн, дээшлүүлсэн, байна.

7.5.3 Рашаан сувиллын нийт эмч нарын 10-аас доошгүй хувь нь анагаах ухааны магистр, мэргэжлийн зэрэг, эрдмийн цолтой байна.

8 Тайлан, мэдээ, мэдээлэл

8.1 Батлагдсан тушаал зааврын дагуу тухайн рашаан сувилалд хөтлөгдвөл зохих маягтуудыг бүрэн хөтөлнө.

8.2 Мэдээ, мэдээллийг дамжуулах

MNS 5232 : 2003

8.2.1 Батлагдсан маягтаар, сар, улирал, жилийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж дээд байгууллагад мэдээлнэ.

8.2.2 Сар, улирал, жилийн тайлан мэдээг нэгтгэн судалгаа хийж дүгнэлт гарган рашаан сувиллын үйл ажиллагааны бодлого боловсруулах, сувилуулагчид болон үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөхөд ашиглах зорилгоор байгууллагын удирдлагад шилжүүлнэ.

8.2.3 Олон улсын хөл хориот болон байгалийн голомтот халдварт өвчин гарсан, байгалийн гамшигт /ган, зуд, үер г.м/ нэрвэгдсэн үед шаардлагатай мэдээллүүдийг /өвчлөл, эндэгдэл, эм тариа, хүн хүч, хүнсний хангамж, машин унаа, шатахуун г.м/ холбогдох байгууллагуудад тушаал, шийдвэрийн дагуу мэдээлж байна.

8.2.4 Рашаан сувиллын бичиг баримт анхан шатны маягт, сар улирал, жилийн тайланг Монгол улсын архивын тухай хууль болон холбогдох тушаал, заавар, журмын дагуу гаргаж хадгална.

9 Сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил

9.1 Рашаан сувилал нь тухайн мэргэжлийн тусламж, эмчилгээ, үйлчилгээний чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхлэж болно.

9.2 Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг удирдаж, хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ, дүгнэлт өгөх үүрэг бүхий сургалт, арга зүйн зөвлөлтэй байна.

9.3 Рашаан сувилал нь сургалт эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн мэргэжлээр рашаан сувиллын дээд, дунд мэргэжилтнийг мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэнэ.

9.4 Эрдэм шинжилгээний ажлын үр дүн

Эрдэм шинжилгээний ажилд оролцох, ажлын үр дүнг туршин шинжлэх буюу үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

10 Рашаан сувилалд сувилуулагчдыг хүлээн авах, эмчлэх

10.1 Эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр онош нь бүрэн нотлогдсон, шаардлагатай бичиг баримт /рашаан сувиллын илгээх карт, ЭМД, иргэний үнэмлэх/ нь бүрдэл болсон сувилуулагчдыг рашаан сувилалд эмчлүүлж болох өвчний жагсаалтыг баримтлан зохих журмын дагуу хүлээж авна.

10.2 Рашаан сувиллын клиникийн тасагт өвчтөн хүлээж авахдаа зохих байгууллагаас батлагдсан журмыг баримтална.

10.3 Сувилуулагчдын талаарх лавлах самбарыг хүлээн авахад ажиллууна.

10.4 Хүлээн авахад Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭМАЭТЗТБ) - аас баталсан маягт РСМ-1, РСМ 12, РСМ-4-ийг хөтөлнө. /Клиникийн тасагтай бол РСМ 13-ийг хөтөлнө./

10.5 Сувилуулагчдын эмчилгээг батласан стандартыг баримтлан явуулна.

10.6 Өвчин хүндэрсэн, онош эргэлзээтэй, эмчилгээ тохирохгүй тохиолдолд эмч нарын хамтарсан үзлэг хийж шийдвэрлэнэ.

10.7 Сувилуулагчыг эмнэлэгт шилжүүлбэл ЭМАЭТЗТБ-аас баталсан журмыг баримтална.

10.8 Сувилуулагчдыг рашаан сувиллаас гаргахад сувиллын дэвтэрт нь тэмдэглэл хийж цаашдын эмчилгээ сувилгаа, дэглэмийн талаар зөвөлгөө өгнө.

11 Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ

Рашаан сувилалд сувилуулагчдад эмчилгээ, сувилгааны чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгоход зориулсан гарын авлага, сургалтын материал, арга зүйгээр эмч мэргэжилтнүүдээ хангана.

12 Эрүүл мэндийн сургалт

Сувилуулагчдад зориулж эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулна.

13 Рашаан сувиллын параклиник

Байнгын ажиллагаатай, клиник тасагтай сувилал нь клиник, биохимийн болон бусад шаардлагатай оношлогоо, шинжилгээг хийх тоног төхөөрөмжтэй байна.

14 Рашаан сувиллын эмийн сан

100- аас дээш ортой рашаан сувилалд эмийн сан ажиллаж, үйл ажиллагаандаа баталсан стандартыг мөрдөнө.

15 Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээ

15.1 Рашаан сувиллын эмчилгээний техник, технологийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

15.2 Эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаатай байх нөхцлийг бүрдүүлж, засвар үйлчилгээний график, төлөвлөгөөтэй ажиллана.

15.3 Эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн техникийн аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдөж ажиллана.

15.4 Рашаан сувилал нь В1, В2, В3, В4 хавсралтуудад заасан багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр, хангагдсан байна.

16 Орчны эрүүл ахуйн шаардлага

16.1 Сувиллын орчин, эрүүл ахуйн шаардлага

16.1.1 Рашаан сувиллын байршил нь байгалийн эмчилгээ /рашаан, шавар, ус/-ний хүчин зүйлийг түшиглэхээс гадна рашааны орд газрын ариун цэврийн хамгаалалтын бүсийн шаардлагыг хангасан байна.

MNS 5232 : 2003

16.1.2 Орчны агаарын бохирдлыг багасгах, уур амьсгалын сөрөг нөлөөллөөс хамгаалах, сувилуулагчдын сэтгэл зүйд таатай орчин бүрдүүлэх, экологийн нөхөн сэргээлтийг сайжруулах зорилгоор эдэлбэр газрын 60%-аас багагүй талбайд ногоон байгууламжтай байна.

16.1.3 Рашаан сувиллын барилга байгууламж нь үйлчлэх хүрээ, ажиллах хүчин чадлаас хамааран 8 га-гаас багагүй эдэлбэр газартай байна.

16.1.4 Ногоон мод бутыг “Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ. MNS 1140:87” стандартын дагуу тарина.

16.1.5 Автомашин, ердийн хөсөг зогсох талбайтай байна.

16.1.6 Рашаан сувиллын орчныг сувилуулагчдын тав тухыг хангахуйц тохижуулж, тоглоомын талбай, амрах саравч, сандал, хогийн сав зэргийг зохих тоогоор байрлуулсан байна.

16.1.7 Рашаан сувиллын орчны шаардлагатай талбай, хэсэг, цэгүүд нь гэрэлтүүлэгтэй байна.

16.1.8 Рашаан сувиллын тусгай хог хаягдлыг халдваргүйтгэл хийж шатаах зууханд устгах ба ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн саванд хийж тогтоосон хугацаанд зайлуулна.

16.1.9 Рашаан сувилал нь тухайн нутаг дэвсгэрт Байгаль орчны хяналтын байгууллагатай экологийн хариуцлагын гэрээ байгуулж, байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байна.

16.2 Барилга байгууламж

16.2.1 Рашаан сувиллын барилга байгууламж нь “Олон нийтийн барилга ,төлөвлөлт, барилгын норм дүрэм. 2.08.02:89*-ийн шаардлагыг хангасан байна.

16.2.2 Рашаан сувиллын барилга байгууламжийн байршил, аюулгүй ажиллагааны урсгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулна.

16.2.3 Рашаан сувилалын эмчилгээ, үйлчилгээний бүх өрөөг агааржуулалтын системээр бүрэн хангасан байх бөгөөд бусад өрөө нь агаарын хэвийн солилцоог хангах ердийн ба механик салхивчтай байна.

16.2.4 Рашаан сувиллын барилгын өрөө тасалгааны талбайн хэмжээний нормативыг С1, С2, С3 хавсралтуудын дагуу мөрдөж ажиллана.

17 Халдвараас сэргийлэх дэглэм

17.1 Сувиллын халдвараас сэргийлэх дэглэмийн шаардлага

17.1.1 Эрүүл ахуйн дэглэм халдвараас сэргийлэх шаардлагыг батласан журмын дагуу хэрэгжүүлнэ.

17.1.2 Рашаан сувиллын дотоод халдвараас сэргийлэх комисс эрүүл ахуй, халдвар судлалын мэргэжилтэн ажиллаж эрүүл ахуйн дэглэм, халдвараас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

17.1.3 Рашаан сувилалд эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэг удаагийн, зүү тариур, материал, багаж хэрэгсэл хэрэглэх ба улсын бүртгэлд бүртгэгдсэн, баталгаат ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэнэ.

17.1.4 Рашаан сувиллын тусламж үйлчилгээнд хэрэглэсэн нэг удаагийн зүү тариур, багаж хэрэгсэл, материалыг холбогдох журмын дагуу зориулалтын шатаах зууханд болон төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн тусгай цэгт устгаж, устгасан тухай тэмдэглэл хөтөлнө.

17.1.6 Рашаан сувиллын цагаан хэрэглэл, бусад зөөлөн эдлэлийг ерөнхий менежерийн тогтоосон журмын дагуу угааж, ариутгана.

17.1.7 Халдварт өвчний сэжиг илэрвэл тусгаарлах өрөөнд оруулж, зохих нарийн мэргэжлийн эмчид үзүүлж шийдвэрлүүлнэ.

17.2 Эмчилгээний багаж материалын ариутгал, халдваргүйтгэл

17.2.1 Эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх зорилгоор эмчилгээ үйлчилгээнд хэрэглэх багаж хэрэгсэл, материалыг ариутгах шаардлага хангасан нөхцөл, урсгал бүхий ариутгалын хэсэгтэй байна.

17.2.2 Төвлөрсөн ариутгал нь нэг чиглэлийн урсгал ажиллагаатай, цэвэр, бохир хэсгүүдийн урсгал холилдохыг хатуу хориглох ба гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй угаалга, ариутгалын материалаар хангасан байна.

18 Рашаан сувиллын ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагаа

18.1 Рашаан сувилал нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй, ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2000” стандартыг мөрдөж ажиллана

18.2 Төвлөрсөн ариутгал, лаборатори, хоолны газар, рентген кабинет, рашаан, ус, шавар эмчилгээний кабинет зэрэг ажлын байр нь агаар сэлгэх төхөөрөмжтэй байх ба “Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ. MNS 12,013 : 91” стандартын шаардлагыг хангасан байна.

18.3 Эмчилгээ үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа автоклав, даралтат сав /хүчилтөрөгч/ шугам хоолойн аюулгүй ажиллагааг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна.

18.4 Химийн бодис, халдвартай материалтай харьцдаг болон хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй багаж, тоног төхөөрөмж, орчин нөхцөлд ажилладаг ажилчдад аюулгүй ажиллагааны талаарх мэдээлэл зааварчилгаар хангаж ажиллана

18.5 Цацраг идэвхит бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүртэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцдаг ажилчид цацрагийн хяналтын эрүүл ахуйн дүрэм,

MNS 5232 : 2003

заавар, журмыг баримтлан ажиллах бөгөөд “Ажлын байрны агаарт байж болох цацраг идэвхит бодисын хэмжээ. MNS 12.05.05:91” стандартыг мөрдөнө. Агаарт буй цацраг идэвхит бодисын хэмжээг тогтоох зориулалтын багаж тоног төхөөрөмжтэй байна.

18.6 “Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS4244:94” стандартын дагуу барилга, байгууламж нь галын аюулгүйн таних тэмдэг бүхий аваарын гарц, шат, авралтын зураг, бүдүүвчтэй байна.

19 Рашаан сувиллын ажилтны эрүүл ахуйн шаардлага

19.1 Рашаан сувиллын ажилчдад зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан хувцас солих, хадгалах болон хооллох, усанд орох өрөөтэй байна.

19.2 Ажилтнуудыг жилд 1-2 удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ба нян тээгч буюу халдварт өвчин илэрвэл үйл ажиллагааг зогсоож, эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

19.3 Рашаан сувиллын ажилтнуудыг тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн 2-оос доошгүй ээлжийн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангана.

19.4 Рашаан сувиллын ажилтанд олгох хувцас хамгаалах хэрэгслийн норматив нь хавсралт “D”-д заасантай тохирч байна.

19.5 Ажиллагсдын ажлын хувцсыг угаах угаалгын газартай байна. Эмнэлэг гал тогооны тасгийн ажилчдын хувцсыг тусад нь авч угаагаад хүлээлгэж өгнө. Угаалгын машин, индүү, стандартын шаардлага хангасан угаалгын нунтаг, саван, ариутгалын бодисоор хангана. Эдгээрийг хадгалах тусгай савтай байна.

20 Сувиллын аж ахуйн үйлчилгээ

20.1 Ажилтнуудын ажлын байр, сувилуулагчдын өрөөний тав тухыг хангасан, цэвэрлэж ариутгах боломжтой, чанартай материалаар хийсэн хатуу, зөөлөн эдлэл, тавилгаар хангасан байна.

20.2 Сувилуулагчдын орны гудас, матрац нь орны хэмжээнд тохирсон, хөнжил нь ноосон буюу хөвөнтэй материалаар, цагаан хэрэглэлийг хүний эрүүл мэндэд харшлахгүй, угааж цэвэрлэхэд хялбар материалаар хийнэ.

20.3 Рашаан сувиллын эмчилгээний кабинетуудад байх хатуу зөөлөн эдлэлийн норматив нь F1, F2, F3, F4, F5, F6, F7, F8 хавсралтуудад заасантай тохирч байна.

20.4 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн ашиглалтын хугацаа, нэг оронд байх нормативыг “G” хавсралтад заасны дагуу мөрдөнө.

20.5 Нөөцийн шинэ хөнжил, цэвэр цагаан хэрэглэлийг тусад нь тусгай тавиурт хадгална.

21 Рашаан сувиллын гал тогоо, хоол хүнсний хангамж

21.1 Рашаан сувиллын газрын хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний зохион байгуулалт нь “Хоолны газрын үйлчилгээ. MNS 4946:2000” стандартын шаардлагыг хангасан байна.

21.2 Ундны ус нь “Ундны усны эрүүл ахуйн шаардлага MNS 900 : 92” стандартын шаардлага хангасан байна.

21.3 Сувилуулагчдад аюулгүйн шаардлага хангасан, өвчтөнд тохирсон эмчилгээний хоолоор үйлчилнэ.

21.4 Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан, эрүүл ахуйн шаардлага хангасан түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, холбогдох стандартын дагуу хадгална.

ТӨГСӨВ.

А. 1 Хавсралт (норматив)

Нэг. Рашаан сувиллын дээд мэргэжилтний орон тоо

1	Мэргэжлийн нэр	Орон тооны доод хязгаар
	а/. Рашаан сувилалд ажиллах эмнэлгийн дээд мэргэжилтэн	
1	Клиникийн тасгийн эмч	40 оронд 2 (Нэг нь тасгийн эрхлэгч, 10-15 хүн үзнэ)
2	Эмчилгээний эмч	40-60 оронд 1
3	Мэдрэлийн эмч	150-иас дээш оронд 1
4	Зүрх судасны эмч	150-иас дээш оронд 1
5	Эмэгтэйчүүдийн эмч	150-иас дээш оронд 1
6	Шүдний эмч	200-аас дээш оронд 1
7	Лабораторийн эмч	200-аас дээш оронд 1
8	Зүү төөнүүрийн эмч	100-аас дээш оронд 1
9	Хүлээн авахын эмч	1
10	Халдвар судлал, эрүүл ахуйч эмч	1
11	Онош зүйн эмч	200-аас дээш оронд 1
12	Хоолны эмч	100-аас дээш оронд 1
13	Дүн бүртгэлийн эмч	1 (өөр ажил хавсрана)
14	Уламжлалт эмчилгээний эмч	100-аас дээш оронд 1
15	Физик эмчилгээ, биеийн тамирын эмч	200-аас дээш оронд 1
16	Арьс гоо заслын эмч	150-иас дээш оронд 1
	<p>ТАЙЛБАР: Нарийн мэргэжлийн эмч нар бүтэн орон тоогоор бус сувиллын эмчээр ажиллаж, мэргэжлийн зөвлөлгөө өгч ажиллана.</p> <p>б. Бусад дээд мэргэжилтэн</p>	
1	Химич	200-аас дээш оронд 1
2	Гидрогеологич	200-аас дээш оронд 1
3	Хоолны инженер, технологич	200-аас дээш оронд 1
4	Бальнотехникийн инженер	200-аас дээш оронд 1

үргэлжлэл

А. 2 хавсралт (норматив)

**Хоёр. Рашаан сувилалд ажиллах эмнэлгийн дунд
мэргэжилтэн**

1	Клиник, биохими, гидрохимийн лаборант	200-аас дээш оронд 1
2	Иллэгийн бага эмч	60 оронд 1
3	Эмчилгээний биеийн тамирын эмч	100 оронд 1
4	Физик эмчилгээний сувилагч	200 оронд 1
5	Шавар эмчилгээний сувилагч	200 оронд 1
6	Рашаан ванн эмчилгээний сувилагч	200 оронд 1
7	Усан засал эмчилгээний сувилагч	200 оронд 1
8	Эмэгтэйчүүдийн эмчилгээний сувилагч	200 оронд 1
9	Гэдэс угаах кабинетийн сувилагч	200-аас дээш оронд 1
10	Жижүүрийн сувилагч	4 ээлжээр
11	Онош зүй, боолтын сувилагч	200-аас дээш оронд 1
12	Рентген техникч	200-аас дээш оронд 1
13	Ариутгагч	Төвлөрсөн ариутгалд 1
14	Сувилахуйн ухааны арга зүйч	200-аас дээш оронд 1
15	Зүүний кабинетийн сувилагч	200-аас дээш оронд 1
16	Утлага эмчилгээний сувилагч	250-аас дээш оронд 1
17	Хүчилтөрөгч коктейлийн сувилагч	250-аас дээш оронд 1

A. 3 хавсралт (норматив)

**Гурав. Удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжлийн
бус бусад ажилтны орон тоо**

1	Захирал /дарга/	1
2	Зөвлөх эмч	200 оронд 1
3	Эмчилгээ эрхэлсэн орлогч	150 оронд 1
4	Хамтын ажиллагаа сургалт хариуцсан мэргэжилтэн	200 оронд 1
5	Чанарын менежер	150 оронд 1
6	Эдийн засаг санхүү эрхэлсэн орлогч	1
7	Боловсон хүчин, хуулийн мэргэжилтэн	100-аас дээш ажилтанд 1
8	Ерөнхий ня-бо	1
9	Тооцооны ня-бо	100 оронд 1
10	Бичээч бичиг хэрэг, архивын ажилтан	1
11	Кассын нярав	1
12	Материалын нярав	1
13	Хүнсний нярав	1
14	Цагаан хэрэглэлийн нярав	1
15	Хангагч нярав	1
16	Ахлах тогооч	100 оронд 1
17	Туслах тогооч	35 оронд 1
18	Сав угаагч, бэлтгэгч	100 оронд 1
19	Зөөгч	40 оронд 1
20	мужаан	100 оронд 1
21	Жолооч	Машины тоогоор
22	Цахилгаан техникч	1
23	Гагнуурчин-слесарь	200 оронд 1
24	Сантехникийн слесарь	50 оронд 1
25	Шавар бэлтгэгч	100 оронд 1
26	Шаврын үйлчлэгч	200 оронд 1
27	Угаагч /цагаан хэрэглэл/	100 оронд 1
28	Жижүүр	4 ээлжээр
29	Манаач	4 ээлжээр
30	Байрны үйлчлэгч	50 оронд 1
31	Ачигч	1 (өөр ажил хавсрана)
32	Малчин	Малын тоог харгалзах
33	Сахиул	1 (өөр ажил хавсрана)
34	Талбайн цэвэрлэгч	1 (өөр ажил хавсрана)
35	Хоолны сувилагч, танхимын зохион байгуулагч	1
36	00-ийн үйлчлэгч	10-12 суудалд 1
37	Кабинетийн үйлчлэгч	2 кабинетэд 1

В. 1 хавсралт (норматив)

Чухал багаж хэрэгслийн тооны доод хязгаар

1	Эмнэлгийн багаж хэрэгслийн нэр	Байвал зохих доод хэмжээ / ширхгээр/
1. Нийтлэг хэрэглэдэг оношлогоо, эмчилгээний багаж		
1	Чагнуур	Эмчийн тоогоор
2	Даралтын аппарат	Эмчийн тоогоор
3	Халуун хэмжигч	Эмчийн тоогоор
4	Хэл дарагч	Эмчийн тоогоор
5	Жин хэмжигч	1
6	Үзлэгийн ор	үзлэгийн өрөөний тоогоор
7	Чангалуур	2-4
8	Хямсаа шүдтэй, шүдгүй	Хүрэлцэхүйц
9	Хайч тахир шулуун	2-3
10	Катетер	4
11	Бургуй тавих хэрэгсэл /эсмарк/	5
12	Мэдрэлийн алх /мэдрэлийн эмчид	1
13	Спирометр	2
14	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Суурин 1, зөөврийн 1
15	Велоэргометр	1
16	Бикс /том, жижиг/	5
17	Боолтын материалын тавиур	1-2
18	Хүчилтөрөгчтэй уут	1-2
19	Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор	1
20	Эм хадгалах шүүгээ	2
21	Сэтгэц нөлөөт болон хүчтэй эмийн шүүгээ	1
22	Бөөрөн хэлбэрт таваг	5
23	Зүү /бөөрөнхий, гурвалжин/	Тус бүр 5
24	Зүү баригч	2-4
25	Мэс заслын нийлэг утас /зүүтэй ба зүүгүй/	Хүрэлцэхүйц
26	Сорох төхөөрөмж /отсос/	1
27	Суурин колпоскоп	1

B. 2 хавсралт (норматив)

2. Физик эмчилгээ

1	Гальванийн аппарат	30 оронд 1
2	Электросоны аппарат	100 оронд 1
3	Диадинамометрийн аппарат	50 оронд 1
4	Амплиппульсийн аппарат	50 оронд 1
5	Дарсонвалийн аппарат	50 оронд 1
6	Индуктотермийн аппарат	50 оронд 1
7	УВЧ-ийн аппарат	50 оронд 1
8	УВЧ- индуктотермийн аппарат	50 оронд 1
9	Франклинizationsийн аппарат	50 орон 1
10	Ультравукийн аппарат	50 оронд 1
11	Соронзон эмчилгээний аппарат	50 оронд 1
12	Дециметр волновой эмчилгээний аппарат	50 оронд 1
13	Хэт улаан туяаны аппарат	50 оронд 1
14	Гэрэл эмчилгээний аппарат	50 оронд 1
15	Хэт ягаан туяаны аппарат	50 оронд 1
16	Лазерийн туяаны аппарат	100 оронд 1
17	Утлагын аппарат	50 оронд 1
18	Парафины ванн	50 оронд 1
19	Эмчилгээний биеийн тамирын иж бүрдэл	50 оронд 1
20	Татлагын ор - хүзүүний - нурууны	50 оронд 1 50 оронд 1
21	Доргиох аппарат	50 оронд 1
22	Динамометр	50 оронд 1
23	Иллэгийн аппарат	30 оронд 1
24	Зүү /эмчилгээний/	Хүрэлцэхүйц
25	Хануурын хутга	Хүрэлцэхүйц
26	Шивүүр	Хүрэлцэхүйц
27	Бумба	Хүрэлцэхүйц
28	Усан эмчилгээний тоног төхөөрөмж	100 оронд 1 ком

үргэлжлэл

В. 3 хавсралт (норматив)**3. Лаборатори**

1	Биохимийн шинжилгээний аппарат	200-аас дээш оронд 1
2	Хуруу шил	Хүрэлцэхүйц
3	Бүрхүүл шил	Хүрэлцэхүйц
4	Тавиур шил	Хүрэлцэхүйц
5	Бичил харуур 2 нүдний	50-иас дээш оронд 1
6	Термостат	50-иас дээш оронд 1
7	Рефрактометр	50-иас дээш оронд 1
8	Коагулометр	50-иас дээш оронд 1
9	Улаан эсийн тунах хурд тодорхойлогч	50-иас дээш оронд 1
10	Хурилдуур /гар ажиллагаатай/	50-иас дээш оронд 1
11	Хурилдуур /цахилгаан/	200-аас дээш оронд 1
12	Гемоглобиномерийн автомат анализатор	50-иас дээш оронд 1
13	Цусны эс тоологч камер /бүрэн автомат/	200-аас дээш оронд 1
14	Цусны эс тоологч /механик ажиллагаатай/	50-иас дээш оронд 1
15	Гемалобиномер /сали/	50-иас дээш оронд 1
16	Шээсний анализатор	50-иас дээш оронд 1
17	pH метр	50-иас дээш оронд 1
18	Вакутайперийн зүү хуруу шилний хамт	Хүрэлцэхүйц
19	Ланцет	Хүрэлцэхүйц
20	Дусаагуур /энгийн/	Хүрэлцэхүйц
21	Дусаагуур /автомат/	200-аас дээш оронд 1
22	Лабораторийн жин	1 ком
23	Усан ванн	1
24	Шээсний цаасан туузан оношлуур	Хүрэлцэхүйц
25	НВ С Ад антиген илрүүлэх цаасан туузан оношлуур	Хүрэлцэхүйц
26	Хөргөгч ердийн	1
27	Ус нэрэгч	1

4. Хэт авиа оношлогоо

1	Эхо аппарат	200- аас дээш оронд 1
2	Зүрхний ЭХО аппарат	200- аас дээш оронд 1
3	ЭХО аппарат зөөврийн	100- аас дээш оронд 1

5. Рентген оношлогоо

1	Суурин рентген аппарат	200 –аас дээш оронд 1
2	Хальс угаагч	1
3	Өсгөгч дэлгэц	1
4	Хальс цэнэглэгч	Хүрэлцэхүйц
5	Дозиметр	Эмч, техникчийн тоогоор

үргэлжлэл

В. 4 хавсралт (норматив)**6. Эмнэлгийн бусад тоног төхөөрөмж**

1	Автоклав	1
2	Хатаагч шүүгээ	1
3	Ус нэрэгч аппарат	1
4	Автомакс	1
5	Бактерицид ламп	Шаардлагаар
6	Ердийн хөргөгч	Шаардлагаар
7	Тахир дутуу хүний тэргэнцэр	50 оронд 1
8	Шилэн шүүгээ	50 оронд 1
9	Дуслын штатив	50 оронд 1
10	Нэг удаагийн зүү тариур устгах аппарат	1
11	Стерилизатор / багаж ариутгагч/	50 оронд 1

7. Эмнэлгийн хэрэгсэл

	а/. Ороох боох материал	
1	Даавуун боолт /төрөл бүрийн/	Хүрэлцэхүйц
2.	Даралттай боолт самбай	Хүрэлцэхүйц
3.	Самбай, шингээгч төрөл бүрийн	Хүрэлцэхүйц
4.	Хөвөн /шингээгч/	Хүрэлцэхүйц
5.	Шархны гоюу /ороомог/	Хүрэлцэхүйц
	б/.Тариур, зүү	
1	Нэг удаагийн тариур 20.0 мл	Хүрэлцэхүйц
2.	Нэг удаагийн тариур 10.0 мл	Хүрэлцэхүйц
3.	Нэг удаагийн тариур 5.0 мл	Хүрэлцэхүйц
4.	Нэг удаагийн тариур 3.0 мл	Хүрэлцэхүйц
5.	Нэг удаагийн тариур 1.0 мл	Хүрэлцэхүйц
6.	Шингэн сэлбэх систем	Хүрэлцэхүйц

8. Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны тоног төхөөрөмж

1	Компьютер принтерийн хамт	1
2	Хувилах машин	1
3	Өсгөгч, микрофоны хамт	1
4	Чанга яригч	1
5	Кодоскоп дэлгэцийн хамт	1
6	Хөгжим	1

С. 1 хавсралт (норматив)

Рашаан сувиллын барилгын өрөө тасалгааны талбайн доод хязгаар

Нэг. Эмчилгээ, үйлчилгээний тасаг, хэсэг

1	Хүлээн авах	12
2	Тарианы өрөө Жижүүрийн сувилагчийн өрөө	12 6
3	Боолтын өрөө /цэвэр/ /бохир/	12 12
4	Зүрхний цахилгаан бичлэг хийх өрөө	24
5	Үзлэгийн эмч нарын өрөө	10
6	Лабораторийн шинжилгээний өрөө	24
7	Шинжилгээний материал хүлээн авах	8
8	Хэт авиа оношлогоо	12
9	Рентген оношлогоо	16
10	Нярав сувилагч	10
11	Ариутгалын өрөө /материал хүлээж авах өрөөтэй байна/	15 6
12	Ажилчдын ажлын хувцас угаах өрөө хатаах өрөө	16 16
13	Индүүдлэгийн өрөө	4

С. 2 хавсралт (норматив)

Эмийн бус эмчилгээний кабинетууд

1	Цахилгаан гэрэл эмчилгээ	1 оронд 6м^2 өрөө нь 12м^2 аас багагүй
2	Зүү эмчилгээний өрөө	1 оронд 6м^2
3	Биеийн тамир эмчилгээ хувцас тайлах өрөө	1 хүнд 5 м^2 өрөө нь 25м^2 -аас багагүй 12м^2
4	Иллэг бариа засал	1 оронд 6м^2
5	Цахилгаанаар унтуулах өрөө	1 оронд 6м^2
6	Шавар эмчилгээ хувцас тайлах шүршүүрийн кабин	1 оронд 6м^2 2 м^2 1 кабинд 2м^2 , 2 оронд 1 шүршүүр
7	Рашаан ванн хувцас тайлах өрөө	1 ваннд 6м^2 2м^2
8	Усан эмчилгээ хувцас тайлах өрөө	25 м^2 8м^2
9	Рашаан уух өрөө	60м^2
10	Мөчний ванн хувцас тайлах өрөөний хамт	18 м^2
11	Усан доториллэг хийх ванн хувцас тайлах кабины хамт	18 м^2
12	Эмэгтэйчүүдийн эмчилгээ хийх хувцас тайлах кабины хамт	12м^2
13	Гэдэс угаах өрөө	12м^2
14	Шавар халаах, төлжүүлэх, хадгалах	24м^2
15	Шавар эмчилгээний зөөлөн эдлэл угаах өрөө	18м^2
16	Утлага эмчилгээний өрөө	1 хүнд 4м^2
17	Хүчилтөрөгчийн коктейль бэлтгэх өрөө	8м^2
18	Шүүс бэлтгэх өрөө	6м^2
19	Тасгийн эрхлэгчийн өрөө	12м^2
20	Нийтийн бие засах газар	16м^2
21	Архив	24м^2
22	Номын сан, /уншлагын заалтай/	24м^2
23	Сургалт, арга зүйн кабинет	16м^2
24	Эм, эмнэлгийн багаж хэрэгсэл хадгалах өрөө	12м^2
25	Мужааны өрөө	18м^2
26	Цахилгаан сантехникийн ажилчдын хувцас солих өрөө	12м^2
27	Цэвэр цагаан хэрэглэл хадгалах өрөө	12м^2
28	Бохир цагаан хэрэглэл хүлээн авах өрөө	6м^2

үргэлжлэл

С. 3 хавсралт (норматив)

	Гурав. Сувилуулагчдын байр	талбай / м ² /
1	1 хүнтэй нэг тасалгаатай өрөө	9
2	2 ортой өрөө	12
3	3 ортой өрөө	18
4	4 ортой өрөө	24
5	Люкс өрөө ариун цэврийн өрөө	Талбай адил 3.7
6	Халуун усанд орох өрөө шүршүүр хувцас тайлах өрөө	8 4
7	Уулзалтын өрөө	12
8	Үзвэрийн танхим	50 ортой сувилалд 160

Гал тогоо

	Өрөөний нэр	Талбай / м ² /
1	Ногоо бэлтгэх	18
2	Мах бэлтгэх	18
3	Бэлтгэлийн	18
4	Хоол үйлдвэрлэлийн	60
5	Аяга таваг угаах	24
6	Хоногийн бүтээгдэхүүн агуулах	18
7	Хөргөх төхөөрөмжийн агуулах Үүнд: Мах, махан бүтээгдэхүүний Сүү, сүүн бүтээгдэхүүний Ногооны агуулах	24 12 12 12
8	Хоолны инженер технологч, хоолны эмчийн өрөө	18
9	Ажилчдын өрөө /хувцас солих/	36
10	Хаягдал гаргах өрөө /гадагш хаалгатай/	6
11	Ажилчдад зориулсан шүршүүр бие засах газар	12
12	Хүнсний агуулах	15
13	Ногооны зоорь	50

D хавсралт (норматив)

**Рашаан сувиллын ажилтанд олгох ажлын хувцас,
хамгаалах хэрэгслийн норматив**

1	Ажил мэргэжил	халад	маска	малгай	цамц	өмд	Хөвөнтэй бээлий	Резин бээлий	Комбинзон	Гарын алчуур	Гарын саван	Хамгаалалтын хормогч	Хамгаалалтын бээлий	Хулдаасан хормогч	Даавуун хормогч	Эсгий гутал	Хөвөнтэй өмд, цамц
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Их эмч	*	*	*				*		*	*						
2	Бага эмч	*	*	*				*		*	*						
3	Сувилагч	*	*	*				*		*	*						
4	Лаборант	*	*	*				*		*	*		*				
5	Ариутгагч	*	*	*						*	*		*				
6	Нягтлан бодогч	*	*							*	*						
7	Бичиг хэрэг архивч	*	*	*						*	*						
8	Цахилгаан сантехникийн инженер	*	*				*		*	*	*		*				
9	Цахилгаан техникч						*	*	*	*	*	*	*				
10	Хоолны инженер технологич	*		*						*	*						
11	Тогооч	*		*						*	*			*	*		
12	Бэлтгэгч сав угаагч	*	*	*						*	*			*	*		
13	Сантехникч		*				*	*	*	*	*						
14	Мужаан		*				*		*	*	*						
15	Жолооч						*		*	*	*						*
16	Угаагч	*	*	*						*	*						
17	Жижүүр									*	*						
18	Манаач сахиул						*			*	*					*	*
19	Нярав	*	*							*	*						
20	Үйлчлэгч		*	*	*	*		*		*	*						
21	Зөөгч	*		*						*	*				*		
22	Шавар бэлтгэгч				*	*		*		*	*			*			
23	Шавар тавигч		*	*	*	*		*		*	*			*			

- Заавал олгогдох ажлын хувцас

F. 1 хавсралт (норматив)

**Эмчилгээний кабинетуудад байх хатуу, зөөлөн эдлэл
/тоног төхөөрөмж/-ийн доод хэмжээ**

1	Кабинетийн нэр	Шаардлагатай эд хогшил	Байвал зохих доод хэмжээ /ширхгээр/
1.	ШАВАР ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1. Өвчтөнийг хэвтүүлж шавар тавих ор /хулдаасан бүрээстэй/	Кабины тоогоор
		2. Өвчтөнийг суулгаж шавар тавих богино вандан сандал, ширээ	Кабины тоогоор
		3. Ноосон буюу зузаан даавуун бүтээлэг	Орны тоогоор
		4. Дэвсгэр даавуу	Хүрэлцэхүйц хэмжээгээр
		5. Эмнэлгийн хулдаас	Хүрэлцэхүйц хэмжээгээр
		6. Цаг	Кабин бүрт
		7. Шаврын температур үзэх термометр	Ажилтны тоогоор
		8. Шавар зөөх хувин	Хүрэлцэхүйц
		9. Резинен бээлий	Ажилтны тоогоор
		10. Шаврын хусуур	Шавар тавигчийн тоогоор
		11. Хаалт, хөшиг	Кабин тус бүрт
		12. Усны гутал	Шавар бэлтгэгчийн тоогоор
		13. Гишгүүр мод	Шүршүүрийн тоогоор
		14. Ширээ	Сувилагчид 1
		15. Сандал	1
		16. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		17. Өвчтөний хувцас олгох өлгүүр, сандал, гишгүүр мод	Кабин тус бүр
		18. Ажилчдын хувцасны шүүгээ	Ажилтны тоогоор
		19. Чагнуур	1
		20. Даралтын аппарат	1
		21. Хогийн сав	1

үргэлжлэл

F. 2 хавсралт (норматив)

2	РАШААН ВАНН ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1.Рашаанд оруулах онгоц	Кабин тус бүрт 1
		2.Гишгүүр мод	Кабин бүрт 1
		3. Хувцас тайлах өрөөнд сандал	Кабин бүрт 1
		4. Зүрхэнд болон толгойд хүйтэн жин тавих даавуу	Хүрэлцэхүйц хэмжээгээр
		5. Цаг	Кабин бүрт
		6.Рашааны температур үзэх термометр	Ванны сувилагчийн тоогоор
		7. Ванн угаах сойз	Ванн тус бүрт
		8. Ариутгалын бодис	Хүрэлцэхүйц
		9. Ванн өнгөлөгч	Хүрэлцэхүйц
		10. Резинэн бээлий	Ванны сувилагч үйлчлэгчийн тоогоор
		11. Угаалгын нунтаг	Хүрэлцэхүйц
		12. Сандал	Сувилагчид 1
		13. Ширээ	Сувилагчид 1
		14. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		15.Ванны хаалт	Ванны тоогоор
		16. Даралтны аппарат чагнуур	Тус бүр 1
		17. Хувцасны шүүгээ	Ажилтны тоогоор
		18. Хогийн сав	1
3	УСАН ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1. Даралтат усаар шүрших төхөөрөмж	Ком 1
		2. Даралтыг хянах манометр /хянах самбар/	Ком 1
		3. Цаг	1
		4. Хувцас тайлах өрөөнд өлгүүр гишгүүр мод, даавуу	2-4
		5. Хаалт хөшиг	2 ээлж
		6. Сувилагчийн сандал	1
		7. Ширээ	1
		8. Чагнуур	1
		9. Даралтны аппарат	1
		10. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		11. Хувцасны шүүгээ	Ажилчдын тоогоор
		12. Салхивч	1
		13. Подводный массаж	200-аас дээш оронд 1 ком
		14. Усан бассейны татлагын төхөөрөмж	200-аас дээш оронд 1 ком
		15. Хогын сав	1

үргэлжлэл

F. 3 хавсралт (норматив)

4	ИЛЛЭГ ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1. Иллэг хийх кабин	Илээчийн тоогоор
		2. Илээчийн суух сандал	Илээчээр тоогоор
		3. Өвчтөнийг суулгах сандал	Илээчийн тоогоор
		4. Хэвтүүлж иллэг хийх модон ор	Илээчийн тоогоор
		5. Иллэгийн цахилгаан аппарат	50 оронд 1
		6. Орны дэвсгэр даавуу	Хүрэлцэхүйц
		7. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		8. Халуун бариа хийхэд зориулсан плитка, таваг, хулдаас	Илээч тус бүрт 1
		9. Хувцасны шүүгээ	Ажилтны тоогоор
		10. өлгүүр	Нэг удаагийн ээлжин орох хүний тоогоор
		11. Гарын угаалтуур	1
		12. Гарын алчуур	Илээч тус бүрт 1
		13. Хогийн сав	1
5	ФИЗИК ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1. Өвчтөнийг хэвтүүлж эмчилгээ хийх модон ор	Кабины тоогоор
		2. Сандал ширээ	Аппаратын тоогоор
		3. Цаг	Кабины тоогоор
		4. Розетка	Аппаратын тоогоор
		5. Орны дэвсгэр даавуу	Хүрэлцэхүйц
		6. Жийргэвч даавуу (электродны)	Хүрэлцэхүйц
		7. Хаалт хөшиг	Кабины тоогоор
		8. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		9. Индикатор	Сувилагийн тоогоор
		10. Өлгүүр	кабины тоогоор
		11. Хувцасны шүгээ	Ажилтны тоогоор
		12. Эмийн бодис	Хүрэлцэхүйц
		13. Жин	1 ком
		14. Цахилгаан зуух	1
		15. Эм хадгалах шүүгээ	1
		16. Ус халаах сав	2
		17. Хогийн сав	1

үргэлжлэл

F. 4 хавсралт (норматив)

6	ЗҮҮНИЙ КАБИНЕТ	1. Өвчтөнийг хэвтүүлж зүү тавих модон ор	50 оронд 2 ор
		2. Орны дэвсгэр даавуу	Орны тоогоор хүрэлцэхүйц
		3. Хөнжил	Орны тоогоор
		4. Эмчилгээний зүү	Хүрэлцэхүйц
		5. Шивүүрийн алх	Эмчийн тоогоор
		6. Хануурын багаж	Эмчийн тоогоор
		7. Төөнүүр	Хүрэлцэхүйц
		8. Бумба	Хүрэлцэхүйц
		9. Цаг	1
		10. Шүдэнз	Хүрэлцэхүйц
		11. Спирт	Хүрэлцэхүйц
		12. Ариутгасан хөвөн бөмбөлөг	Хүрэлцэхүйц
		13. Ариутгалын бодис	Тогтмол сольж хэрэглэх
		14. Хуруу шил	Хүрэлцэхүйц
		15. Хаалт хөшиг	орны тоогоор
		16. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		17. Сандал ширээ	Ажилтны тоогоор
		18. Хогийн сав	1
7	ЭХО ОНОШЛОГООНИЙ КАБИНЕТ	1. Эхо аппарат	Суурийн (зөөврийн)
		2. Ширээ сандал	Сувилагч эмчийн тоогоор
		3. Өвчтөн хэвтүүлэх ор	1
		4. Зориулалтын тос	хүрэлцэхүйц
		5. Зориулалтын хувилах цаас	хүрэлцэхүйц
		6. Хувцасны шүүгээ	Ажилтны тоогоор
		7. Өлгүүр	1
		8. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		9. Хогийн сав	1

үргэлжлэл

F. 5 хавсралт (норматив)

8	ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ КАБИНЕТ	1. Үзлэг эмчилгээ хийх зориулалтын ор	1
		2. Үтрээний толь	хүрэлцэхүйц
		3. Бээлий / үзлэгийн/	хүрэлцэхүйц
		4. Ариутгалын бодис	Тогтмол солих
		5. Хулдаас буюу полиэтилен цаас	хүрэлцэхүйц
		6. Хувцасны өлгүүр	1-2
		7. Сандал	1
		8. Шаахай	1-2
		9. Сувилагчийн суух сандал ширээ	1
		10. Хувцасны шүүгээ	1
		11. Хаалт	1
		12. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		13. Ариутгасан багаж хадгалах бикс	1-2
		14. Эмчилгээнд хэрэглэх зарим эм	хүрэлцэхүйц
		15. Ариутгасан бөмбөлөг, сальфетка	хүрэлцэхүйц
		16. Спирт денатурат	хүрэлцэхүйц
		17. Иод	хүрэлцэхүйц
		18. Хямсаа	хүрэлцэхүйц
		19. Шилэн шүүгээ	1
		20. Кольпоскоп (үтрээний дуран)	1
		21. Хогийн сав	1
9	РАШААНААР ГЭДЭС УГААХ ЗАСАЛ	1. Өвчтөнийг хэвтүүлж климз тавих модон ор	1
		2. Клизм тавих эсмарк	1-2
		3. Гэдэс угаахад хэрэглэх хошуу	Хүн тус бүрт
		4. Гэдэс угаах хошууг ариутгах, ариутгалын бодис бүхий сав	Паалантай буюу шилэн сав, бодисыг тогтмол сольж байх тус бүр 1
		5. Хошууг буцалгаж ариутгах сав, плитка	Тус бүр 1
		6. Үнэр дарагч бодис	Хүрэлцэхүйц
		7. Сувилагчийн бээлий	Хүрэлцэхүйц
		8. Гэдэс угаах рашааны төхөөрөмж	Ком 1
		9. Кабины хаалт	Кабин тус бүрт
		10. Хулдаас	Хүрэлцэхүйц
		11. Хогийн сав	1

үргэлжлэл

F. 6 хавсралт (норматив)

10	ХҮЧИЛТӨРӨГЧИЙН ЭМЧИЛГЭЭ	1. Хүчилтөрөгч /баллонтой/	1-2
		2. Бобровын аппарат	1
		3. Сироп болон жимсний шүүс бэлтгэх паалантай сав	1-2
		4. Өндөг задлагч	1-2
		5. Сандал, ширээ /сувилагчийн/	Тус бүр 1
		6. Үйлчлүүлэгчийн ширээ	1
		7. Тусгаарлах кабин	1
		8. Ариутгалын бодис	Хүрэлцэхүйц
		9. Сандал	Хүрэлцэхүйц
		10. Хөргөгч	1
		11. Коктейльд оролцох материал	Хүрэлцэхүйц
		12. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		13. Хувцасны шүүгээ	Сувилагчид 1
		14. Хогийн сав	1
11	ХҮЛЭЭН АВАХ	1. Ширээ	1
		2. Сандал	3
		3. Өвчтөн үзэх ор	1
		4. Телефон утас	1
		5. Хувцасны шүүгээ	1
		6. Эм хадгалах шүүгээ	1
		7. Цонхны хөшиг	Цонхны тоогоор
		8. Лавлах самбар	1
		9. Хүлээн авахад хөтлөх маягтууд	Хүрэлцэхүйц хэмжээгээр
		10. Хүлээн авахын тэмдэг	1
		11. Тамганы тосны суурь	1
		12. Хогийн сав	1
12	УТЛАГА ЭМЧИЛГЭЭ	1. Утлага эмчилгээний төхөөрөмж	50 оронд 1
		2. Утлагад хэрэглэх эмийн бодис	Хүрэлцэхүйц
		3. Утлагын хошуу	Хүрэлцэхүйц
		4. Эмийн бодис хийх аяга	Хошууны тоогоор
		5. Утлагын хошуу аягыг ариутгах ариутгалын бодистой сав	1
		6. Утлагын хошуу аягыг буцалгаж ариутгах сав	1
		7. Халуун ус	Хүрэлцэхүйц
		8. Өвчтөнийг суулгах сандал	Хүрэлцэхүйц
		9. Сувилагчийн сандал ширээ	Тус бүр 1
		10. Цахилгаан зуух (Плитка)	1
		11. Ус буцалгах сав	1
		12. Хогийн сав	1

үргэлжлэл

F. 7 хавсралт (норматив)

13	ЖИЖҮҮР СУВИЛАГЧИЙН ӨРӨӨ	1. Шилэн шүүгээ	1
		2. Хорт эм хадгалах шүүгээ	1
		3. Өвчтөн хэвтүүлж үзэх ор	1
		4. Хүчилтөрөгчийн уут	2
		5. Яаралтай тусламжийн эм	Хүрэлцэхүйц
		6. Тариур /хэмжээ тус бүрээс/	Хүрэлцэхүйц
		7. Бээлий	Хүрэлцэхүйц
		8. Чангалуур	1
		9. Эсмарк	1
		10. Дуслын хөл (штатив)	1-2
		11. Бикс	2
		12. Хэл дарагч	Хүрэлцэхүйц
		13. Халууны шил	Хүрэлцэхүйц
		14. Зонд	Хүрэлцэхүйц
		15. Катетер	Хүрэлцэхүйц
		16. Сандал	2
		17. Ширээ	1
		18. Хямсаа	1-2
		19. Боолтын материал	Хүрэлцэхүйц
		20. Жин хэмжигч	1
		21. Өндөр хэмжигч (Ростометр)	1
		22. Хогийн сав	2

үргэлжлэл

F. 8 хавсралт (норматив)

14	БИЕИЙН ТАМИР ЭМЧИЛГЭЭНИЙ ӨРӨӨ	1. Ханын толь	1 хананд
		2. Ханын шат	1 хананд 2
		3. Гудас	Хүрэлцэхүйц
		4. Хивс, хивсэнцэр	Бүтэн дэвсгэр
		5. Дэвсгэр даавуу	Матрацны тоогоор 2 ээлж
		6. Цаг	1
Эмчилгээнд хэрэглэх багаж төхөөрөмжүүд Үүнд:			
		7. Гантель	50 оронд 1 ком
		8. Савх мод	Хүрэлцэхүйц
		9. Цагираг	Хүрэлцэхүйц
		10. Бөмбөг	Хүрэлцэхүйц
		11. Спандрууд	Хүрэлцэхүйц
		12. Угломер (өнцөг хэмжигч)	1
		13. Жин хэмжигч	1
		14. Динамометр	1
		15. Хөгжим	1
		16. Салхивч	1
		17. Дасгал хийхэд зориулсан сандал	10-аас доошгүй
		18. Татлагын аппарат	100 оронд 1
		19. Тренежер	Ком 1
		20. Механик эмчилгээний төхөөрөмж	Ком 1
		21. Хогийн сав	1
		22. Хувцасны шүүгээ	1
		23. Өлгүүр	Хүрэлцэхүйц
24. Ширээ, сандал	Тус бүр 1		
15.	РЕНТГЕНИЙ ӨРӨӨ	1. Рентгений аппарат	1
		2. Рентген хальс /төрөл бүрийн/	Хүрэлцэхүйц
		3. зургийн хавчаар	Хүрэлцэхүйц
		4. Зургийн урвалж	Хүрэлцэхүйц
		5. Хамгаалалтын нүдний шил	Эмч, техникчдийн тоогоор
		6. Хамгаалалтын бээлий	Эмч, техникчийн тоогоор
		7. Хамгаалалтын хормогч	Эмч, техникчийн тоогоор
		8. Хальс угаагч	1
		9. Өсгөгч дэлгэц	1
		10. Хальс цэнэглэгч	Хэмжээ бүрээс 1
		11. Дозиметр	Эмч, техникчийн тоогоор
		12. Сандал ширээ	Тус бүр 1
		13. Цонхны хар хөшиг	Цонхны тоогоор
		14. Хувцасны шүүгээ	Эмч, техникчийн тоогоор
		15. Хальс хатаагч	1
		16. Хогийн сав	1

G хавсралт (норматив)

**Рашаан сувиллын нэг оронд байх цагаан хэрэглэл,
зөөлөн эдлэлийн хангалт, ашиглах хугацаа**

1	Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн нэр	Хэмжих нэгж	Нэг оронд байх цагаан хэрэглэл, зөөлөн эдлэл	
			Тоо	Нэг бүрийн эдлэгдэх хугацаа (сараар)
1.	Матрац (гудас)	ш	2	48
2.	Матрацны уут	ш	4	36
3.	Дэр	ш	1	48
4.	Дэрний уут	ш	4	36
5.	Орны дэвсгэр даавуу	ш	4	36
6.	Хөнжлийн даавуу	ш	4	36
7.	Хөвөнтэй хөнжил	ø	1	48
8.	Орны бүтээлэг	ø	2	36